

## 1.Шинээр газар өмчлөх

- Иргэний үнэмлэхний хуулбар
- Оршин суугаа баг, хорооны засаг даргын /тосгоны захирагчийн/ тодорхойлолт;
- Газрын тухай хуулийн дагуу газар эзэмшиж байгаа бол газар эзэмших эрхийн гэрчилгээний эх хувь;
- Хүсэлт гаргасан газрын байршлыг харуулсан тойм зураг;

## 2. Өмнө нь гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар дундаа хамтран өмчилсэн бөгөөд тухайн газрын өмчлөх эрхийг гэрээний үндсэн дээр гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлсэн иргэн шинээр газар өмчилж авахыг хүсвэл

- Иргэний үнэмлэхийн үнэмлэхний хуулбар
- Оршин суугаа баг, хорооны Засаг дарга /тосгоны захирагч/-ын тодорхойлолт
- Хүсэлт гаргасан газрын байршил, хэмжээг харуулсан тойм зураг
- Өмнө нь гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар дундаа хамтран өмчилж авсан газрын өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар эсвэл аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрийн эх хувь
- Өмнө нь гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар дундаа хамтран өмчилж авсан газрын өмчлөх эрхийг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх талаар гэр бүлийн

гишүүдийн харилцан тохиролцож байгуулсан “Газар өмчлөх эрх шилжүүлэх” гэрээний эх хувь

- Гэрээний үндсэн дээр гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлсэн газрын өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

## 3. Иргэний эрх, үүргээ биечлэн хэрэгжүүлэх боломжгүй буюу хууль ёсны төлөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан газар өмчилж авахыг хүссэн иргэн дараах материалыг бүрдүүлнэ. /0-16 насны хүүхдэд хамаарна/

- Өргөдөл гаргагчийн иргэний үнэмлэх /төрсний гэрчилгээ/-ийн хуулбар
- Өргөдөл гаргагчийн оршин суугаа баг, хорооны Засаг дарга /тосгоны захирагч/-ын тодорхойлолт
- Хүсэлт гаргасан газрын байршил, хэмжээг харуулсан тойм зураг
- Өргөдөл гаргагчийн хууль ёсны төлөөлөгч /итгэмжлэгдсэн төлөөлөгч/-ийн иргэний хуулбар
- Хууль ёсны төлөөлөгч /итгэмжлэгдсэн төлөөлөгч/ мөн болохыг нотлох баримт бичиг буюу хууль ёсны төлөөлөгчөөр томилсон Засаг даргын шийдвэр, шүүхийн шийдвэрийн хуулбар, итгэмжлэлийн эх хувь

**Хэрэв өргөдөл гаргагч нь өмнө нь гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар дундаа хамтран өмчилсэн байсан бол дараахь баримт бичгийг хавсаргана:**

- Өмнө нь гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар дундаа хамтран өмчилж авсан газрын өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар эсвэл аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрийн эх хувь
- Өмнө нь гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар дундаа хамтран өмчилж авсан газрын өмчлөх эрхийг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх талаар гэр бүлийн гишүүдийн харилцан тохиролцож байгуулсан “Газар өмчлөх эрх шилжүүлэх” гэрээний эх хувь
- Гэрээний үндсэн дээр гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлсэн газрын өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

Өөр суманд газар өмчлөх хүсэлт гаргахад **газар өмчилж байгаагүй тухай тодорхойлолтыг** харъяа сумын газрын даамлаас, бусад аймаг, суманд газар өмчлөхөд ГХБХБГазраас **газар өмчлөлийн лавлагааг** авна.

Хаяг:Хэрлэн сум, 1-р баг,Тэмүүжиний гудамж, ГХБХБГазрын байр 107 тоот  
Утас: 70562008, 70563841  
Цахим хаяг:[www.khentii.gazar.gov.mn](http://www.khentii.gazar.gov.mn)

**Хэнтий аймаг  
ГБХБХГазар**

**ГАЗРЫН ХАРИЛЦАА,  
БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**



***Газар өмчлөхөд  
бүрдүүлэх  
материал***

**2017 он**